



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 29 өдөр

Дугаар A/84

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.
3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эс-Пи Сервис ХХК -ийн "Сансар" дэн буудлын 13/29, Алтаннаран ХХК-ийн "Эрхэс" зочид буудлын 13/03, Алтаннаран ХХК-ийн "247" зочид буудлын 13/05, Иргэн П.Амардэлгэрийн "Ундроул" зочид буудлын 13/117 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 08 сарын 29 өдрийн  
A/84 дүгээр тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.08.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Алтаннаран ХХК	Эрхэс	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж За
2	Алтаннаран ХХК	247	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж За
3	Иргэн П.Амардэлгэр	Үндрал	Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Намъянжугийн гудамж 20

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 08 сарын 29 өдрийн  
A/84 дүгээр тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СҮНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.08.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Үндецим Үндецим ХХК	Элеганс	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж 16/3

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 08 сарын 29 өдрийн  
A/84 дүгээр тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.08.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эс-Пи Сервис ХХК	Сансар	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Их тойруу 30/1

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 08 сарын 29 өдрийн  
А/84 дүгээр тушаалын дөрөвдүгээр  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СҮНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.08.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эс Пи Би ХХК	Соёмбо	Сүхбаатар дүүрэг, 16-р хороо, Бэлхийн 34/04
2	Иргэн Л.Бурмаа	Мини	Баянгол дүүрэг, 14-р хороо, 18/1
3	Иргэн Л.Тамир	Орж гарч байлдаа хө	Сонгинохайрхан дүүрэг, Ногоон чулуут 5/10

-ооОоо-